47.5.Энэ хуулийн 47.1.5-д заасан сургалтыг оюуны өмчийн байгууллага болон түүнээс эрх олгосон хуулийн этгээд зохион байгуулна. Сургалт зохион байгуулах журмыг оюуны өмчийн байгууллагын дарга батална.

#### **48 дугаар зүйл.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа**

48.1.Хамтын удирдлагын байгууллага нь өөрийн гишүүн зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийг төлөөлж, тэдний нэрийн өмнөөс, тэднээс олгосон бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

48.1.1.батлагдсан тарифын дагуу бүтээл ашиглах лиценз авсан этгээдээс төлбөр хураан авах;

48.1.2.энэ хуулийн 48.1.1-д заасан төлбөрөөс зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

48.1.3.гишүүн зохиогчийн бүтээлийг хууль бусаар ашигласан тухай мэдээллийн дагуу холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх;

48.1.4.зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрхийг хамгаалах асуудлаар гэрээгээр тусгайлан олгосон эрхийн хүрээнд итгэмжлэлгүйгээр шүүх болон бусад төрийн байгууллагад төлөөлөх;

48.1.5.гадаад улсын ижил төрлийн хамтын удирдлагын байгууллагатай хамтран ажиллах, харилцан төлөөллийн гэрээ байгуулах;

48.1.6.гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

48.2.Хамтын удирдлагын байгууллагын зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн бүтээл ашиглах онцгой эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.





48.3.Хамтын удирдлагын байгууллагыг бүртгэх, гэрээ байгуулах, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

48.4.Хамтын удирдлагын байгууллага нь жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор оюуны өмчийн байгууллагад дараах мэдээллийг ирүүлнэ:

48.4.1.үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;  
48.4.2.хураасан төлбөр, хуваарилалтын дэлгэрэнгүй мэдээлэл;

48.4.3.бүтээлийг ашиглуулахаар байгуулсан гэрээний мэдээлэл;

48.4.4.гишүүдэд тайлан тавьсан тухай хурлын тэмдэглэл.

48.5.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгасан байна:

48.5.1.зохиогчийн эрх, хамаарах эрхийн төрөл, ангилал тус бүрд цуглуулсан төлбөрийн мэдээлэл, гишүүдэд хуваарилсан төлбөрийн дүн, захиргааны зардал болон төлөгдөөгүй бүтээл ашиглалтын төлбөрийн дүнгийн талаарх тухайн жилийн санхүүгийн мэдээлэл;

48.5.2.тухайн жилд хамтын удирдлагын байгууллагын байгуулсан лицензийн гэрээний тоо, үнийн дүн, гэрээний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй тайлан;

48.5.3.удирдлага, зохион байгуулалтын бүтэц;  
48.5.4.бусад хамтын удирдлагын байгууллагатай хэрэгжүүлсэн хамтын ажиллагааны талаарх мэдээлэл;

48.5.5.хамтын удирдлагын байгууллагын дүрэмд заасан бол соёл, урлаг, боловсролыг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл.

#### **49 дүгээр зүйл.Хамтын удирдлагын байгууллагын үүрэг**

49.1.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах талаар дараах үүрэг хүлээнэ:

49.1.1.зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашигласны төлбөрийг олгохдоо тухайн бүтээлийг ашигласантай холбогдолтой мэдээллийг танилцуулах;

49.1.2.лицензийн дагуу хураан авсан бүтээл ашигласны төлбөрийг зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчид хуваарилан олгох;

49.1.3.бүтээл ашигласантай холбогдуулан хураан авсан төлбөрөөс үйл ажиллагааны зардлыг хасаж, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчид тогтмол хугацаанд бүтээл ашиглалтын хэмжээгээр хувь тэнцүүлэн хуваарилах;

49.1.4.энэ хуулийн дагуу холбогдох байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, үүсгэн байгуулах баримт бичиг, дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллага, гишүүдэд мэдэгдэх.

49.2.Төлбөр хураан авах, хуваарилахтай холбоотой журам болон үйл ажиллагааны зардалд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг бүх гишүүдийн хурлаар батална.

49.3.Хамтын удирдлагын байгууллага нь үйл ажиллагааны зардлыг суутгасны дараа бүтээл ашигласны төлбөрийг баталсан хуваарилалтын журмын дагуу гишүүдэд хуваарилна.

49.4.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааны зардал нь бүтээл ашиглалтын нийт төлбөрийн үнийн дүнгийн 25 хувиас ихгүй байна.

49.5.Хамтын удирдлагын байгууллагын гишүүн хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, бүтээл ашиглалтын батлагдсан тариф, төлбөр хуваарилалтын журам, өөрийн бүтээлийн ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хамтын удирдлагын байгууллагаас шаардах эрхтэй.

49.6.Хамтын удирдлагын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

## **50 дугаар зүйл.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт**

50.1.Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд оюуны өмчийн байгууллага хяналт тавина.

50.2.Хамтын удирдлагын байгууллага энэ хуулийг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол оюуны өмчийн байгууллага зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулна.



50.3.Оюуны өмчийн байгууллага дараах тохиолдолд хамтын удирдлагын байгууллагын бүртгэлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

50.3.1.батлагдсан төлбөрөөс илүү хэмжээгээр төлбөр хураан авсан;

50.3.2.батлагдсан төлбөр дээр нэмэлт төлбөр ногдуулж авсан;

50.3.3.энэ хуулийн 48.4, 48.5-д заасан тайлан, мэдээллийг ирүүлээгүй;

50.3.4.энэ хуулийн 50.2-т заасан үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй.

50.4.Оюуны өмчийн байгууллага дараах тохиолдолд хамтын удирдлагын байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээг цуцалж, бүртгэлийг хүчингүй болгоно:

50.4.1.энэ хууль болон хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл зохиогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж үйл ажиллагаа явуулсан;

50.4.2.хууран мэхэлж, эсхүл хууль бус аргаар зөвшөөрөл авсан нь нотлогдсон;

50.4.3.энэ хуульд заасан тайлан, мэдээллийг худал мэдүүлсэн нь нотлогдсон;

50.4.4.үйл ажиллагаагаа ашгийн төлөө болгож өөрчилсөн;

50.4.5.бүртгэлийг түдгэлзүүлэх шийдвэрийг үл харгалзан үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулсан;

50.4.6.үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлж, гэрээ байгуулснаас хойш нэг жилийн дотор үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл нэг жилээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй.

50.5.Энэ хуулийн 50.4.1-д заасан ноцтой зөрчлийг оюуны өмчийн байгууллага, хамтын удирдлагын байгууллагатай байгуулах хамтран ажиллах гэрээнд нэрлэн заана.

50.6.Энэ хуулийн 50.3, 50.4-т заасны дагуу гаргасан шийдвэрийг оюуны өмчийн байгууллага нийтэд мэдээлнэ.

50.7.Энэ хуулийн 50.3, 50.4-т заасан оюуны өмчийн байгууллагын шийдвэрийг хамтын удирдлагын байгууллага үндэслэлгүй гэж үзвэл холбогдох хуульд заасан журмын дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

50.8.Хамтын удирдлагын байгууллагыг татан буулгахдаа оюуны өмчийн байгууллагаас зөвшөөрөл авна.

### **51 дүгээр зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөл**

51.1.Зөвлөл нь зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн байгууллагад зөвлөх, бүтээл ашиглалтын тарифыг хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.

51.2.Зөвлөл нь дарга, 14 гишүүнээс бүрдэнэ.

51.3.Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг оюуны өмчийн байгууллага хэрэгжүүлнэ.

51.4.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. Зөвлөлийг нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

51.5.Зөвлөлийн дарга, гишүүнд урамшуулал олгоно.

51.6.Зөвлөл нь хамтын удирдлагын байгууллагаас санал болгосон бүтээл ашиглалтын тарифын нөхцөл нь зах зээлийн үнэлгээнээс хэт өндөр, бүтээлийн хэвийн ашиглалт, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзвэл бүтээл ашиглалтын тарифыг баталгаажуулахгүй байж болно.

51.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, гомдлыг урьдчилан шийдвэрлэх, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51.8.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

**НАЙМДУГААР БҮЛЭГ  
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ЗОХИОГЧИЙН  
ЭРХ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

**52 дугаар зүйл.Цахим болон харилцаа холбооны бусад  
сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах**

52.1.Интернетийн үйлчилгээ түгээгч, агрегатор, цахим хуудас эрхлэгч, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон сувгийн дамжуулагч нь өөрийн болон бусад сервер, сүлжээ, санд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

*Тайлбар: Энэ хуульд заасан “агрегатор” гэдэгт контент цуглуулах, нийлүүлэх болон эдгээрийг олон нийтэд санал болгож байгаа этгээдийг ойлгоно.*

52.2.Энэ хуулийн 52.1-д заасан этгээд нь зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдсэн даруй тухайн зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглалтыг зогсоох, хаах үүрэг хүлээнэ.

52.3.Энэ хуулийн 52.1, 52.2-т заасан үүргээ биелүүлээгүй этгээдэд оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд<sup>4</sup> заасан хариуцлага ногдуулна.

52.4.Оюуны өмчийн улсын байцаагч нь зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар яаралтай арга хэмжээ авах зорилгоор зөрчилтэй үйлдлийг зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зогсоох, эсхүл үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох арга хэмжээг нэн даруй авах эрхтэй.

52.5.Энэ хуулийн 52.1, 52.2-т заасны дагуу зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглахыг зогсоосон, хаасантай холбоотой маргааныг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

52.6.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүтээл ашиглах этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа бол зохиогчийн эрхийн зөрчлийг арилгах арга хэмжээ авхуулахаар холбогдох байгууллагад хандах эрхтэй.

<sup>4</sup> Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

### **53 дугаар зүйл. Технологийн хамгаалалтын арга хэмжээ**

53.1. Зохиогч, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн энэ хуульд заасан эрхийг хэрэгжүүлэх, өөрийн бүтээл, хамаарах эрхийн объектыг зөвшөөрөлгүйгээр ашиглахаас урьдчилан хамгаалах зорилгоор хэрэглэж байгаа технологийн хамгаалалтыг санаатайгаар эвдэх, идэвхгүйжүүлэх, устгах, гэмтээхийг хориглох бөгөөд эдгээр үйлдлийг зохиогчийн эрх, эсхүл хамаарах эрхийн зөрчилд тооцно.

53.2. Технологийн хамгаалалтыг эвдэх, идэвхгүйжүүлэх, устгах, гэмтээх үндсэн зориулалттай технологи, тоног төхөөрөмжийг арилжааны зорилгоор үйлдвэрлэх, импортлох, сурталчлах, санал болгох, түрээслэх, нийлүүлэхийг хориглох бөгөөд эдгээр үйлдлийг зохиогчийн эрх, эсхүл хамаарах эрхийн зөрчилд тооцно.

53.3. Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн үйл ажиллагаанд энэ хуулийн 53.1, 53.2-т заасан зохицуулалт хамаарахгүй.

### **54 дүгээр зүйл. Эрхийн удирдлагын мэдээлэл**

54.1. Эрхийн удирдлагын мэдээллийг бүтээлийн хуулбар, тоглолт, фонограммын бичлэгт хавсаргасан, эсхүл хуулбар дотор агуулсан байдлаар байршуулсан, эсхүл эдгээрийг цахим орчинд дамжуулах, нийтийн хүртээл болгоход ил тод байдлаар байршуулна.

54.2. Эрхийн удирдлагын мэдээллийг зохиогч болон хамаарах эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуульд заасан эрхийг зөрчих боломж олгох, эсхүл зөрчлийг нуун дарагдуулах зорилгоор санаатайгаар устгах, өөрчлөх, эсхүл нэмэлт хийхийг хориглох бөгөөд эдгээр үйлдлийг зохиогчийн эрх, эсхүл хамаарах эрхийн зөрчилд тооцно.

54.3. Эрхийн удирдлагын талаар гуйвуулсан мэдээлэл агуулсан бүтээлийн хуулбар, тоглолт, фонограммын бичлэгийг нийтэд түгээх, импортлох, нийтэд дамжуулах, нийтэд ашиглах боломж олгохыг хориглох бөгөөд эдгээр үйлдлийг зохиогчийн эрх, эсхүл хамаарах эрхийн зөрчилд тооцно.

54.4. Монгол Улсын нийтлэг ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн үйл ажиллагаанд энэ хуулийн 54.1, 54.2, 54.3-т заасан зохицуулалт хамаарахгүй.

### **55 дугаар зүйл. Зохиогч болон тоглогч уран бүтээлчийн амины эрхийг хамгаалах**

55.1. Бүтээлийн халдашгүй байдал болон зохиогчийн, эсхүл тоглогч уран бүтээлчийн амины эрхийг зөрчсөн тохиолдолд зохиогч болон тоглогч

уран бүтээлч нас барсан бол түүний өв залгамжлагч, өв залгамжлагчгүй бол оюуны өмчийн байгууллага нь зөрчигдсөн эрхийг зохих журмын дагуу сэргээн тогтоолгох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эдийн бус гэм хорыг арилгуулахаар уг эрх зөрчсөн этгээдээс шаардах, шүүхэд гомдол гаргах эрхтэй.

### **56 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон хамаарах эрхийн зөрчилд тооцогдох үйлдэл**

56.1.Зохиогчийн эрх болон хамаарах эрхийг дараах тохиолдолд зөрчсөнд тооцно:

56.1.1.зохиогчийн эрхийн бүтээл, хамаарах эрхийн объектыг зохиогч, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр, гэрээ байгуулахгүйгээр ашиглах, гэрээний нөхцөл, журмыг зөрчих;

56.1.2.зохиогчийн эрх болон хамаарах эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг ашгийн зорилгоор үйлдвэрлэх, түгээх, тээвэрлэх;

56.1.3.энэ хууль болон гэрээнд заасан төлбөр төлөх үүргээ биелүүлэхгүй байх;

56.1.4.зохиогч болон тоглогч уран бүтээлчийн амины эрхийг зөрчих;

56.1.5.эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг олон нийтийн сүлжээнд байршуулах, интернетийн /цахим/ холбоос хийх, хөгжүүлэлт хийх;

56.1.6.хуульд заасан бусад.

### **57 дугаар зүйл.Зохиогчийн эрхийн тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

57.1.Зохиогчийн эрхийн тухай хууль зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай, эсхүл Эрүүгийн хуульд<sup>5</sup> заасан хариуцлага хүлээлгэнэ.

57.2.Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирол болон эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх асуудлыг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

57.3.Эрх нь зөрчигдсэн зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд зөрчилтэй бүтээгдэхүүнийг хохирлын

<sup>5</sup> Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.





























706 КМТНН ХМДГ .. ХОНССТН ДДМ БИЛМ Ө БХД

706 . 6 . ХОНССТН ФЕКТЕЛМ МР ДДМ УМОВ КФ БХШТНБ БИЛМ Ө БХД БКХЛГ А :

706 . 6 . 6 . ФЕКТЕЛМ ДДМ БХФОН МР ФЭИМ ХОНСЛГ . НШМТМ ННН А ӨНН . БИЛМГ А ННН А БХОНН ӨНН НХКХЛМГ .

706 . 70 . 6 . ХОНСЛГ . НШМТМ ННН А ДН ХОНССТН ДДМ ХОУЛЫНХН БХЛН ӨНН БХЛНХЛМГ . ХКНТНЭИМ ДН УМХСЛМГ .

706 . 70 . 6 . ФЕКТЕЛМ Н НСНГ ДДМ РЕХКЛГ ФЭИТЭМ . БИЛМБИМГ ММСН ФЭДН КФ ННН А ӨМР МХКНЭИМГ .

706 . 6 . 6 . ФЕКТЕЛМ ФЭИМ ФЕКТЕЛМ МР ННН А ДН ХОНССТН ДДМ ХОУЛЫНХН БХЛН ӨНН . БИЛМГ А ННН А РЕДК КФ БДН УМХСЛМГ

МХКНЭИМГ ММДМР ӨХКЛМ ДДМ БИЛМГ БХТН А . ЛЮИХН ӨНН РЕУИТЭСИМ . МНДХЛМГ . НЭКНЭИМГ БИЛМГ ДН УМХСЛМГ ..

706 КМТНН ХМДГ .. ХОНССТН ДДМ БК РЕХКНЛГ ДДМ ММТМНН БХД

706 . 6 . ХОНССТН БНН БХФОН МР ФЕКТЕЛМ Н ФЭЛЭН МР БХТН А . ЛЮИХН ӨНН БИЛМБИМГ БК РЕХКНЛГ ДДМ ММТМНН БХД АХНСЛМГМ » ФЕКТЕЛМ

БИЛМБИМГ ММТМНН БХД « РЕУ БКХЛГ А ..

706 . 70 . ХОНССТН ДДМ ФЕКТЕЛМ БИЛМБИМГ ММТМНН БХД КФ БХШТНБ БХД ДН РЕБНХНЭИМГ А :

706 . 6 . 70 . НШМТМФЭИТЭМГ .

706 . 70 . 70 . НСНГ КФ БХЛНМГ .

706 . 70 . 70 . НСНГ КФ БИКНЭИМГ .

706 . 70 . 70 . НСНГ КФ БИЛМБИМГ .

706 . 70 . 70 . НСНГ КФ БИЛНМГ МХСЛМГ .

706 . 70 . 70 . ММХСЛМГ БИЛМГ .

706 . 70 . 70 . БИЛМБИМГ ФЭИТЭМ БХЛНХЛМГ ..



















17) КМШН ХМХГ .. МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

18) . 6 . МХСР ХХММ . МХСР ХХИЙГ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ КӨ ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ КӨ ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

19) . 7 . МХСР ХХММ . МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МОНГОЛЫН ХӨГӨМӨ

МОНГОЛЫН ХӨГӨМӨ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

20) КМШН ХМХГ .. МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

21) . 6 . МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

22) . 6 . 6 . МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

23) . 7 . 6 . МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ

МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ МАНДИРАГ МЭДИЙГ МР ХӨГӨН ДХМ ХМХГ





































































## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зохиогчийн эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үсэнтүгч Бямба нар

Хийсгэнэгийн Бямба нар

Бямба нар 09 - 09 - 2021 он

Хэрэгсэл хийх үйлдвэр  
Хийсгэнэгийн Бямба нар

6 Күн хийх үйлдвэр .. 2021 он 06 - 09  
Хийсгэнэгийн Бямба нар  
Хийсгэнэгийн Бямба нар ..

7 Күн хийх үйлдвэр .. Бямба нар  
Хийсгэнэгийн Бямба нар ..

Хийсгэнэгийн Бямба нар  
Хийсгэнэгийн Бямба нар



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3, 4 дэх хэсэг нэмсүгэй:

“3.Хамтын удирдлагын байгууллага батлагдсан төлбөрийн хэмжээнээс илүү хэмжээгээр төлбөр хураан авсан, батлагдсан төлбөр дээр нэмэлт төлбөр ногдуулсан, хуульд заасан тайлан, мэдээг зохих хугацаанд ирүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хамтын удирдлагын байгууллага үйл ажиллагаагаа ашгийн төлөө болгож өөрчилсөн, хууль болон хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, зохиогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж үйл ажиллагаа явуулсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэрийг үл харгалзан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эрх болон түүнд хамаарах” гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Зохиогчийн эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Оюуны өмчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:**

“6.5.Энэ хуулийн 6.3-т заасан сайн дурын бүртгэл хөтлөх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

#### **2/12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалт:**

“12.2.3.хамтын удирдлагын байгууллага, зохиогчийн эрхийг хамгаалах, төлөөлөх эрхийг хэрэгжүүлэх байгууллага, бүтээл ашиглагч болон төрийн байгууллагыг зохиогчийн эрхийн талаарх мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах.”

**2 дугаар зүйл.** Оюуны өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хянах” гэснийг “хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Оюуны өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “эрх болон түүнд хамаарах” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Зохиогчийн эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнөөс улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжих суурь нөхцөл, хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор нь эрэмбэлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлага, төсвийн орлогын нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**









**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2022 онд шаардлагатай хөрөнгө			Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Эх үүсвэр	8		
1	2	3	4	5	6	7	8	9	
<p>Бүлэг 1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого</p> <p>Зорилго 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>									
1.1.1	МУТЖУЧ-2.4.1, ЗГУАХ-1.1.2	Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох	Судалгааны ажил эхлэх шатанд байна.	Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон байна. Вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлсон байна.	600.0	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-	
1.1.2	МУТЖУЧ-2.4.1, ЗГУАХ-1.1.3	Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх	Нөөцийн бэлэн байдлыг эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрээр тухай бүрд тооцон гаргаж байна.	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна.	-	-	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга	

1.1.3	МҮТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХ-1.1.3	Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулах тус тус байгуулах	Тооцоо, судалгаа хийгдсэн.	Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулсан байна.	1,220.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймгийн Засаг дарга
1.1.4	МҮТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХ-1.1.3	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн агуулах шинэчлэн барих барилгын ажлыг эхлүүлж, 30 хувьд хүргэх	0 хувь	Агуулахын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.	1,000.0	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-
1.1.5	МҮТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-1.1.3	5 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр бүрэн хангаж, шинээр 5 аймгийн нэгдсэн эмнэлгийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжтэй болгож, лабораторийн чадавхыг нэмэгдүүлсэн байна.	6 аймагт полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх молекул биологийн лаборатори байгуулагдсан.	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр бүрэн хангаж, шинээр 5 аймгийн нэгдсэн эмнэлгийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжтэй болгож, лабораторийн чадавхыг нэмэгдүүлсэн байна.	1,500.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймгийн Засаг дарга



1.1.6	МҮТЖҮЧ-2.1.10, ЗГҮАХ-1.1.12	Ерөнхий боловсролын 100 сургуульд сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн санг сонголттойгоор бүрдүүлэх	Ерөнхий боловсролын 45 сургуульд сургалтын удирдлагын системийг туршсан.	Ерөнхий боловсролын 100 сургуульд үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
1.1.7	ЗГҮАХ-1.1.7	Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктэй хэлэлцэн тохирч, идэвхтэй хамтран ажиллах	I үе шат буюу 100.0 сая ам.доллар	Төсвийн тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг хүлээж авсан байна.	296.000.0	Гадаадын зээл, тусламж	Сангийн сайд	-
1.1.8	ЗГҮАХ-1.1.10	Улсын төсөв, Засгийн газрын дотоод үнэт цаасны эх үүсвэр, гадаад хөнгөлөлттэй зээлээс Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит хуулийн этгээдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон өр авлагыг барагдуулах	I үе шат буюу 100.0 сая ам.доллар	Засгийн газрын эх үүсвэрээр олгосон ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг банк, санхүүгийн байгууллагад худалдан эх үүсвэрийг төвлөрүүлэх, дамлуурсан банкууд дээрх улсын төсвийн авлагын асуудлаар Монголбанк,	-	-	Сангийн сайд	-

<b>Бүлэг 2.Хүний хөгжлийн бодлого</b>								
<b>Зорилго 2.1.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.</b>								
				банкуудын эрх хүлээн авагчидтай хамтран ажиллаж, хууль, журмын дагуу шийдвэрлүүлж, Төрийн орон сууцны корпораци болон Засгийн газрын тусгай сангуудаас улсын төсөвт төлөх өглөгийг бууруулсан байна.				
2.1.1	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3	Зурх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын зуралтал, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн.	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	40,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.2	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх	0 хувь	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн төхөөрөмж, бусад/тооцооллыг хийсэн байна.	40,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.3	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3	Сурьээгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын зуралтал, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн. Газрын асуудал баталгаажсан.	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.	8,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-



2.1.4	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3	Геронтологийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хирлэх	Барилгын ажлын гүйцэтгэл 46 хувьтай байна.	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	5,600.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	
2.1.5	МУТЖҮЧ-2.2.4, ЗГҮАХ-2.1.4	Орон нутагт яаралтай тусламжийн 10 цэг байгуулах	Орон нутагт яаралтай тусламжийн цэг байхгүй.	Орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулсан байна.	5,000.0	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.1.6	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.3	Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх	Төсөл, тооцоолол батлагдсан.	Зураг, төсөв хийгдэж, барилгын ажил эхэлсэн байна.	-	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.7	МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-2.1.6	Эрүүл мэндийн салбарын 26 байгууллагад мэдээллийн сүлжээний дэд бүтэц бий болгох	48 байгууллагын сүлжээний дэд бүтцийн санхүүжилтийг бүрэн шийдвэрлэсэн.	26 байгууллага сүлжээний дэд бүтэцтэй болсон байна.	700.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
2.1.8	МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-2.1.6	Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх	Мэдээлэл солилцооны платформ нэвтрээгүй.	Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтрэсэн байна.	9,800.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
2.1.9	МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-2.1.6	Дүрс архивлан хадгалах, дамжуулах (PACS)/ нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Эрүүл мэндийн байгууллагад PACS систем ашиглаж эхлээгүй.	Эрүүл мэндийн байгууллагуудад PACS систем бүрэн ашиглагдаж эхэлсэн байна.	5,800.0	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-
2.1.10	МУТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-2.1.6	Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн А зэрэглэлийн сумын зэрэглэлийн сумын бүрдсэн.	Эрүүл мэндийн 29 байгууллагад телемедицин ашиглах боломж бүрдсэн.	Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн	500.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-

2.1.11	МҮТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.6	Эрүүл мэндийн төвд телемедицин нэвтрүүлэх Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх	Төлөвлөлтийн шатанд байна.	Эрүүл мэндийн цахим бүртгэлийн тогтолцоо нэвтрэсэн байна.	600.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.12	МҮТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-2.1.7	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 94.2 хувьтай байна.	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 94.2 хувьтай байна.	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 95 хувьд хүрсэн байна.	-	-	Эрүүл мэндийн сайд	-
2.1.13	МҮТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-2.1.7	Олон улсын эмнэлэгийн удирдамжийн цахим санг нэвтрүүлэх	Цахим санг нэвтрүүлэх гэрээг олон улсын байгууллагатай байгуулсан.	Олон улсын эмнэлэгийн удирдамжийг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлсэн байна.	1,400.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.14	МҮТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ-2.1.8	Эм ханган нийлүүлэх байгууллагуудад эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх	Төлөвлөлтийн шатанд байна.	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтад эм ханган нийлүүлэх байгууллага 100 хувь хамрагдсан байна.	-	-	Эрүүл мэндийн сайд	-





2.1.15	МҮТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ-2.1.8	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх	8 аймгийн нэгдсэн эмнэлгийн лаборатори сүлжээнд холбогдсон.	21 аймгийн нэгдсэн эмнэлэг сүлжээнд холбогдож, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна.	500.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.16	МҮТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ-2.1.8	Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг эх орнодо үйлдвэрлэдэг болоход түүхий эдийг татаараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл дотоодын зах зээлийн 1.4 хувийг эзэлж байна.	Хууль, эрх зүйн орчин бүрдэж, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь нэмэгдсэн байна.	-	-	Эрүүл мэндийн сайд	-
2.1.17	МҮТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-2.1.9	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадварыг бэхжүүлэх	Төгсөлтийн дараах сургалтыг 2 бүсийн оношилгоо, эмчилгээний төвд явуулж байна.	Шинээр 3 бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт явуулдаг болсон байна.	250.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.1.18	МҮТЖҮЧ-2.2, ЗГҮАХ-2.1.13	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ.	4 багцыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн.	Бүх өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ.	250.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-



		иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх	Төлөвлөлтийн шатанд байна.		Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	3,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.19	МУТЖУЧ-2.2.2, ЗГУАХ-2.1.1	"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөлтийн шатанд байна.		Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	3,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.20	МУТЖУЧ-2.2.2, ЗГУАХ-2.1.1	"Хавдрын эсрэг" арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ зохион байгуулах	Төлөвлөлтийн шатанд байна.		Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын түвшин 30 хувьд хүрсэн байна.	600.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.21	МУТЖУЧ-2.2.2, ЗГУАХ-2.1.1	"Элэг бүлэн Монгол" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний дельта вирусгүй ирсэдийг эмчилгээнд хамруулах	Төлөвлөлтийн шатанд байна.		Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	13,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.22	МУТЖУЧ-2.2.2, ЗГУАХ-2.1.1	"Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөлтийн шатанд байна.		Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	200.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.23	ЗГУАХ-2.1.4	Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж,	Чадавх бэхжүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлэх шаардлагатай тоног		Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхжсэн байна.	8,100.0	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-



2.1.24	Техник, тоног төхөөрөмжөөр хангах  МҮТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-2.1.7	Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах	Эрүүл мэндийн даатгалуудад e-health, h-info, health.gov.mn програмуудыг ашиглаж байна.	Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно.	300.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
2.1.25	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх	Барилгын зураглал хийгдсэн.	Цогцолбор салбар II-ын барилга баригдаж эхэлсэн байна.	600.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	-
2.1.26	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	933.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга	
2.1.27	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах	-	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 8 хувиар байгуулсан байна.	40,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	-
2.1.28	Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах	Газар шийдэгдсэн. Ажлын даалгавар хийгдсэн.	Зураг, төсөв хийгдэж, барилгын ажлыг эхлүүлсэн байна.	3,000.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-	-
2.1.29	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан	Ариун цэврийн төвлөрсөн болон хэсэгчилсэн системд холбогдсон	3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн	423.0	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	Барилга, хот байгуулалтын сайд	

		ариун цэврийн байгууламжтай болгох	эрүүл мэндийн байгууллагын тоо-98.	жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.				
2.1.30	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-1.1.3	"Ковид-19" халдварт вирусийн эмчилгээнд нэн шаардлагатай уушги орлуулагч ЭКМО аппаратын тоог нэмэгдүүлэх	Улсын хэмжээнд 2 ЭКМО аппарат ашиглаж байна.	Уушги орлуулагч ЭКМО аппарат худалдан авч эмчилгээнд ашигласнаар тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.	750.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	-
2.1.31	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.12	Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлын хийх	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжсэн.	Тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	8,750.0	Улсын төсөв	Эрүүл мэндийн сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.1.32	МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.1.11	Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих	Азийн хөгжлийн банкны төсөл батлагдсан.	Барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 40 хувьд хүргэсэн байна.	5,137.5	Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн сайд	-
<b>Зорилго 2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.</b>								
2.2.1	МУТЖҮЧ-3.5.2, ЗГҮАХ-2.2.3	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбоорын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Газар, зураг төсөл бэлэн болсон.	Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	25,000.0	Гадаадын зээл, тусламж	Ерөнхий сайд	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
2.2.2	МУТЖҮЧ-3.5.2, ЗГҮАХ-2.2.3	Нийслэлийн усан бассейнд бүхий спортын цогцолбоорын ажлыг үргэлжлүүлж,	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90-95 хувьтай байна.	Спортын цогцолбоорыг ашиглалтад оруулсан байна.	3,400.0	Улсын төсөв	Ерөнхий сайд	-



Зорилго 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.						
	Баянзүрх, Налайх дүүргийн спортын цогцолборыг ашиглалтад оруулах					
2.3.1	МҮТЖҮЧ-2.1.8; ЗГҮАХ-2.3.9	Төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн 113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах	Санхүүжилт шийдвэрлэгдсэн.	113 цэцэрлэг, 176 сургууль, 121 дотуур байр төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болсон байна.	50,000.0	Төр-хувийн хэвшлийн түншлэл  Боловсрол, шинжлэх ухааны сайд
2.3.2	МҮТЖҮЧ-2.1.1; ЗГҮАХ-2.3.2	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд нэмж хамруулах; 24 цагийн 10 бүлэг нээж 250 хүүхдийг шинээр хамруулах	Хувилбарт сургалтад 17141 хүүхэд хамрагдсан. 32 цэцэрлэгийн 24 цагийн 77 бүлэгт 2226 хүүхэд хамрагдсан. Нийт хамран сургалт 93.4 хувьтай байна.	Шинээр 50 гэр бүлэг байгуулж, хувилбарт сургалтад 500 хүүхэд, 24 цагийн 10 бүлэг шинээр нээж 250 хүүхэд нэмж хамруулсан байна. Хамран сургалтыг 95 хувьд хүргэсэн байна.	13,645.3	Улсын төсөв  Боловсрол, шинжлэх ухааны сайд

2.3.3	МУТЖУЧ-2.1.2; ЗГҮАХ-2.3.3	Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	Бага ангид суралцагчдын унших чадварын түвшин 37.5 хувь, бичих чадварын түвшин 37.5 хувь, математик чадварын түвшин 53.3 хувь, дунд ангийн суралцагчдын ерөнхий чадварын түвшин 37.5 хувь, ахлах ангийн суралцагчдын ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хичээлийн түвшин өмнөх онтой харьцуулбал тус тус 5-10 хувиар өссөн байна.	600.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
2.3.4	МУТЖУЧ-2.1.2; ЗГҮАХ-2.3.3	Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын /PISA/ үнэлгээнд хамрагдах	Судалгаанд хамрагдах бэлтгэлийг ханган туршилт, шалгалтуудыг эхлүүлсэн. Хэрэгжилт 30 хувьтай байна.	5,415.0	Гадаадын зээл, тусламж	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-



2.3.5	МҮТЖҮЧ-2.1.3; ЗГҮАХ-2.3.4	Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах	Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг үнэлгээнд дунд, ахлах анги төгсөгчдийг хамруулсан байна. Монгол бичгийн хэвлэмэл болон цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	
2.3.6	МҮТЖҮЧ-2.1.3; ЗГҮАХ-2.3.4	Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэлээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлж, хос хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Гадаад улсад амьдарч байгаа хүүхдэд зориулсан веббэд суурилсан цахим сурах бичиг 1-ийг боловсруулсан.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	
2.3.7	МҮТЖҮЧ-2.1.3; ЗГҮАХ-2.3.4	Хүүхдийн ялгаатай онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн өмнөх боловсролд тэгш хамруулах журам батлагдсан. Хэрэгжилт 25 хувьтай байна.	60.0	Гадаадын зээл, тусламж	Боловсрол, шинжлэх ухааны сайд	

2.3.8	МУТЖУЧ-2.1.7, ЗГАХ-2.3.8	Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	-Багш бэлтгэх их, дээд сургууль болон боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, судлаачдын хамтарсан судалгаанд санхүүжилт олгохоор судалж эхэлсэн. -Ментор багштай сургууль, цэцэрлэгийн тоо-0; -Ментор багштай хамтран хөгжиж байгаа багшийн хувь-0; -Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоо бүрдээгүй.	-Багш бэлтгэх их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, судлаачдын хамтарсан судалгаанд санхүүжилт олгосон байна. -10 аймаг, 5 дүүргийн ерөнхий боловсролын сургууль ментор багштай болсон байна. -Нийт багш нарын 44.7 хувь ментор багштай хамтран хөгжиж боломж бүрдсэн байна. -Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.	150.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
2.3.9	МУТЖУЧ-2.1.7, ЗГАХ-2.3.8	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийг ялгаатай хэрэгцээт боловсролын чиглэлээр	-Ерөнхий боловсролын сургуулийн 165, цэцэрлэгийн 230 багшийг мэргэшүүлсэн байна.	20.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	





			ажилтнуудыг чадавжуулах сургалтад 100, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад чадавжуулах" сургалтад 100, нийт 200 багшийг мэргэшүүлсэн.	-Цэцэрлэгт ээлжийн 200 багш ажиллуулсан байна.				
2.3.10	мэргэшүүлж, цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах	Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлэхэд бүх шатны байгууллагад дэмжлэг үзүүлэх	80 сургууль, 80 цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлсэн байна.	140 сургууль, 140 цэцэрлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлсэн байна.	300.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
2.3.11	МҮТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Сонгинохайрхан дүүрэгт сувицлын цэцэрлэг, сургуулийн барилгыг шинээр барих, ерөнхий боловсролын 25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлэх	2021 оны улсын төсөвт Сонгинохайрхан дүүрэгт 150 хүүхдийн хүчин чадалтай тусгай сургууль, 200 хүүхдийн хүчин чадалтай тусгай цэцэрлэгийн барилгын ажлын төсөв батлагдсан.	-Сонгинохайрхан дүүрэгт сувицлын цэцэрлэг, сургуулийн барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 70 хувьд хүргэсэн байна.  -25 болон 63 дугаар тусгай сургуулийн барилгыг өргөтгөх ажлыг эхлүүлсэн байна.	4,500.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-

2.3.12	<p>Бүх насны иргэд насан туршидаа суралцах боломжийг дэмжих, тэдгээрийн бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож өргөжүүлэх</p>	<p>Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулсан.</p>	<p>Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайд</p>	
2.3.13	<p>Боловсролын цахим шилжилтийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн систем, тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, цахим сургалтын нэгдсэн платформийг хөгжүүлэх</p>	<p>Боловсролын ерөнхий боловсролын 60 хувь холбогдсон. -Цахим сургалтын нэгдсэн платформд теле хичээл,</p>	<p>-Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, сургалтын платформын хөгжүүлэлт 50 хувьтай байна. -Боловсролын нэгдсэн сүлжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 60 хувь хувь холбогдсон. -Цахим сургалтын нэгдсэн сүлжээнд төрийн өмчийн ерөнхий боловсрол</p>	<p>-Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийг боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холбож, өндөр хурдны интернэт үйлчилгээг үзүүлдэг болсон байна.</p>	<p>7,500.0</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайд</p>	



				интерактив контент, сурах бичиг зэрэг 3900 гаруй контент байршуулсан.	-Цахим ээлжит хичээлийн 10000 контент бэлтгэсэн байна. -Төрийн өмчийн 500 цэцэрлэг интернэтэд холбогдсон байна. -Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим агуулга баяжсан байна.				
2.3.14	ЗГҮАХ-2.3.13	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Насан туршийн боловсролын үндэсний төвийг шинэчлэн зохион байгуулж, боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт; Үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгох	Суурь судалгаа 10 хувьтай хийгдэж байна.	Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээ, насан туршийн боловсролын байгууллагын хууль, эрх зүйн орчин бүрдэж, үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн байна. Хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.					Боловсрол, шинжлэх ухааны сайд

2.3.15	МҮТЖҮЧ-2.1.4, ЗГҮАХ-2.3.14	Дээд боловсролын чанарын тогтолцоо, судалгааны чадавхыг олон улсын жишиг, туршлагад үндэслэн сайжруулж, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх	Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөлд төрийн өмчийн их, дээд сургуульд төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой зохицуулалт тусгагдсан.	-Хууль, эрх зүйн орчинтой уялдуулан 5 дүрэм, журмыг шинэчлэн боловсруулсан байна.  -Судалгааны чадавхыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, 200 багш, албан хаагчийг хамруулсан байна.	500.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
2.3.16	МҮТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдыг сургууль дээр ундны ус уух боломжийг бүрдүүлэх	Нийт сургуулийн 30 хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан.	Нийт сургуулийн 50 хувьд ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан байна.	500.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
2.3.17	МҮТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9	Цэцэрлэг сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан ерөнхий боловсролын 50 сургууль, 60 цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулах	-	Шинээр ерөнхий боловсролын 50 сургууль, 60 цэцэрлэг ашиглалтад оруулсан байна.	417,008.5	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-



2.3.18	МҮТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10	Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх	Нөхцөл байдлын судалгааг хийж, судалгааны үр дүнгээр хүүхдийн хоолны зардлын нормативыг үе шаттайгаар нэмэгдүүлэх тооцоог хийсэн. Цэцэрлэгийн 247040 хүүхэд, дотуур байрны 36000 хүүхэд хамрагдсан.	Хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шим тэжээлэг хоол хүнсээр үйлчлэх боломж бүрдсэн байна. Цэцэрлэгийн 289144 хүүхэд, дотуур байрны 38000 хүүхэд хамрагдсан байна.	35,240.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-
2.3.19	МҮТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10	Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг шинэчлэх, мэргэжлийн хүний нөөцөөр хангах	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдад үдийн цайны үйлчилгээг хүргэж байна.	2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдыг, 2022-2023 оны хичээлийн жилээс дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.3.20	МҮТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10	Зориулалтын хоол үйлдвэрлэлийн байргүй ерөнхий боловсролын 18 сургуульд шинээр өргөтгөл барих, 225 сургуулийг стандартын шаардлага	18 сургууль зориулалтын байргүй, 225 сургууль стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжгүй байна.	Ерөнхий боловсролын сургуулиудад хоол үйлдвэрлэлийн асуулгүй орчин бүрдсэнээр эрүүл, шим тэжээлэг хоол хүнсээр хангах нөхцөл бүрдэнэ.	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд	Аймаг, нийслэлийн Засаг дарга

	хангасан тоног төхөөрөмжөөр хангах	Зорилго 2.4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна.						
2.4.1	Судалгааны үр дүнд бий болсон бүтээлийг олон улсад бүртгүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний чанарыг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үйлчилгээг үзүүлж, шилдэг бүтээлийг урамшуулах	Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/131 дугаар тушаалаар шилдэг эрдэм шинжилгээний шалгаруулах журмыг баталж, дотоодын 1 сэтгүүл олон шинжлэх ухааны үйлчилгээг үзүүлж, шилдэг бүтээлийг урамшуулах	-Судалгааны үр дүнд бий болсон шинэ мэдлэг, патентын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, патент эзэмшигчид мөнгөн урамшуулал олгосон байна. -Олон улсын болон дотоодын судалгааны үр дүнд бий болсон шинэ мэдлэг, мэдээллийг ашиглах лицензийн гэрээний төлбөрийг төлсөн байна. -Эрдэм шинжилгээний байгууллагуудад эрх олгож, судлаачдын хандалтын тоог нэмэгдүүлсэн байна. -Олон улсын хянан магадлагаа хийгддэг сэтгүүлүүд дэх монгол эрдэмтдийн бүтээл, эшлэлийн тоо тус бүр нэмэгдэж, шилдэг	500.0	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны сайд	-	

